

БИДНИЙ ЭРХЭМ ЗОРИЛГО

*Даяаршлын эринд ажиллаж,
амьдрах чадвартай, өндөр
мэдлэгтэй мэргэжилтэн
бэлтгэж, Монгол орныхоо
одоо, ирээдүйн хөгжилд хувь
нэмэр оруулна.*

ЗОХИОМЖ ХЭВЛЭЛИЙН ЗОРИЛГО


*Зохиомж дээд сургуулийн
эрдэмтэн багш, эрдэм
шинжилгээний ажилтанууд болон
бакалавр, магистрын зэргээр
өдөр болон оройн ангид сурч буй
нийт оюутануудыг шаардлагатай
мэдээ мэдээллээр хангах орчныг
бүрдүүлэхэд оршино.*

Алтны экспорт 46 хувиар нэмэгдсэн байна



Ашигт малтмалын бүтээгдэхүүний олборлолт, экспорт нэмэгдсэн талаар Уул уурхайн яамнаас мэдээллээ. Тодруулбал, энэ оны эхний дөрвөн сарын байдлаар зэсийн баяжмалын үйлдвэрлэл 305.8 мянган тонн болж, молибдений баяжмал 1.2 мянган тонн, алт 1.4 тонн, нүүрс 6.9 сая тонн, жонш 92.2 мянган тонн, төмрийн хүдэр 0.9 сая тонныг олборлосон байна. Харин экспортоор 5.4 сая тонн нүүрс, 316.5 мянган тонн зэсийн баяжмал, 1.4 мянган тонн молибдений баяжмал, 2.5 тонн алт, 83.0 мянган тонн жонш гаргажээ. Үүнийг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад зэсийн баяжмал 41 хувиар, алт 46.5 хувиар, газрын тосны бүтээгдэхүүн 32.3 хувиар, нүүрсний экспорт 7.3 хувиар, тус тус өссөн дүн гарчээ.

Алтны олборлолт ба экспорт



Хөрөнгө оруулалтын сан байгуулах журмыг баталлаа



Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит хуралдаанаар “Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэх байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ыг хэлэлцэн баталлаа. Өнгөрсөн онд батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль” он гарснаар хэрэгжиж эхэлсэн бөгөөд хуулийн хүрээнд Хөрөнгө оруулалтын санг байгуулах, үйл ажиллагаа явуулах журмыг ийнхүү Санхүүгийн зохицуулах хорооноос баталж байгаа юм.

Энэхүү журам батлагдсанаар дотоодын аж ахуйн нэгжүүд, хувь хүн, цаашилбал гадаадын хөрөнгө оруулагчид мэргэшсэн хөрөнгө оруулалтын байгууллагаар дамжуулан хөрөнгийн зах зээлд оролцох боломж бүрдэж байна.

Валютын ханш

	АНУ доллар	1,818.65
	Евро	2,475.36
	Японы иен	17.89
	Швейцар франк	2,027.59
	Шведийн крон	273.31
	Английн фунт	3,047.15
	ОХУ-ын рубль	52.35
	БНХАУ-н юань	291.13
	БНСУ-ын вон	1.78
	Канадын доллар	1,679.12
	Малайзын ринггит	566.03
	Туркийн лира	868.34

Газрын тосноос гаргаж авдаг бүхий л төрлийн бүтээгдэхүүнийг нүүрснээс гаргах боломжтой



УИХ-ын дарга З.Энхболд нүүрсийг “цэвэр нүүрс” болгох тал дээр ажилладаг дэлхийн тэргүүлэгчдийн “World clean coal conference” хурлыг нээж үг хэлэв.

Монгол Улсын эдийн засагт уул уурхайн салбар томоохон жин эзэлж буй. 2013 оны статистикаас үзвэл Монгол Улсын ДНБ-ний 18.5 хувийг уул уурхайн салбар үйлдвэрлэж, нийт экспортын 82 хувийг эрдэс бүтээгдэхүүн эзэлж байна. Үүний дотор нүүрсний экспорт нийт экспортын 26 хувийг бүрдүүлжээ. Иймээс энэ салбарыг тогтвортой хөгжүүлэх нь манай улсын эдийн засагт тэргүүлэх ач холбогдолтой юм хэмээн УИХ-ын дарга онцлон тэмдэглэв.

Мөн тэрбээр, УИХ өнгөрсөн онд тогтоол гаргаж нүүрснээс шингэн түлш гарган авах технологийн тоног төхөөрөмж, сэлбэг болон тусгай зориулалтын барилгын материалыг гаалийн албан татвараас 2018 оныг дуустал чөлөөлж дэмжлэг үзүүлж байгаа. Хүрэн нүүрсийг шингэрүүлж, хийжүүлж эрчим хүчний зорилгоор ашиглахаас гадна ойрын ирээдүйд химийн аж үйлдвэрийн түүхий эд болгох замаар удахгүй дуусч магадгүй газрын тосыг орлуулах талаар туршилт хийгээд эхэлжээ. Газрын тосноос гаргаж авдаг бүхий л төрлийн бүтээгдэхүүнийг нүүрснээс гаргах боломжтой. Ирээдүйтэй энэ салбарын талаар одооноос бодож эхлэх нь зүйтэй хэмээн хуралд оролцогчдод хандан хэлсэн юм.


Түүнчлэн та бүхнийг манай улсын хүрэн нүүрсний салбарт хөрөнгө оруулах, тоног төхөөрөмж технологио зарах болон бүхий л талаар хамтран ажиллахыг урьж байна гээд Монгол улсын УИХ, засгийн газрын зүгээс Та бүхнийг улс төр, хууль эрх зүйн хувьд тогтвортой орчин, хөрөнгө оруулалтын таатай байдал болон татварын тогтвортой бодлогоор дэмжиж ажиллана гэдгээ илэрхийллээ.

Нийслэл Европын хөрөнгө оруулалтын банкт хамтран ажиллана



Улаанбаатар хотын гэр хорооллыг иргэдийн оролцоотой дахин төлөвлөх, усан хангамж, цэвэрлэх байгууламж, дулааны үйлчилгээг нэмэгдүүлэх, нийгэм эдийн засгийн дэд бүтцийг сайжруулж, бичил санхүүжилтийг дэмжих, төслийг хэрэгжүүлэх байгууллагын чадавхижуулах зэрэг зорилго бүхий “Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 172 дугаар захирамжаар Эдийн засгийн хөгжлийн сайдад гарын үсэг зурах эрхийг олгосон.

Энэ хөтөлбөрт Европын хөрөнгө оруулалтын банк Нийслэлийн гэр хорооллын усан хангамж, ариун цэврийн байгууламжид зориулан 50 сая еврогийн (60.3 сая ам.доллар) санхүүжилтийг хийхээр тусгагдсан бөгөөд 2014 оны 5 дугаар сарын 19-нөөс 21-ний хооронд Люксембургийн Их Вант Улсад зохион байгуулагдсан Европын хөрөнгө оруулалтын банкт хийх зээлийн нөхцөлийг тохирох урьдчилсан хэлэлцээнд Эдийн засгийн хөгжлийн яамнаас Хөрөнгө оруулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Жавхланбаатараар ахлуулсан ажлын хэсэг оролцон урьдчилсан хэлэлцээг амжилттай хийлээ. Тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нийслэлийн Засаг даргын Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан орлогч дарга С.Очирбат, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төсөл, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Д.Отгонбаатар, мэргэжилтэн Ц.Баярсайхан, Эдийн засгийн хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа, зээл, тусламжийн бодлогын газрын мэргэжилтэн Ц.Равдандаш нар ажиллажээ гэж Нийслэлийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсээс мэдээллээ.



Эдийн засгийн өсөлтийг хоёр оронтой тоонд хадгалах зорилт тавина

2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн танилцуулгад эдийн засгийн өсөлтийг хоёр оронтой тоонд хадгалах зорилтыг 2014 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ хэмээн тусгасан байна. Энэ хүрээнд Чингис бонд, Хөгжлийн банкнаас оруулах хөрөнгө оруулалтаас гадна экспортын орлогыг нэмэгдүүлэх талаар тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа бөгөөд тухайлбал, Тавантолгойн нүүрсний бүлэг орд дээр олборлолт явуулж байгаа компаниудын үйл ажиллагааг уялдуулах, экспортыг нэгдсэн байдлаар зохион байгуулах, нүүрс угаах үйлдвэрт бусад компаниудын нүүрсийг боловсруулж, тээврийн зардлыг бууруулах, үнэ өртгийг нэмэгдүүлэх ажлыг эхлүүлжээ. Боомтын төмөр замыг 2014 онд барьж дуусгах, зарим боомтыг байнгын ажиллагаатай болгож, ажиллах цагийг уртасгах, төмрийн хүдрийг нойтон аргаар баяжуулах үйлдвэр болон барилгын арматурын үйлдвэрийг санхүүжилтээр дэмжих, Тавантолгой-Гашуун сухайтын хатуу хучилттай авто замын тарифыг бууруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Алтны олборлолтыг дэмжих, хууль бус алтны олборлолт, худалдааг багасгаж, Монголбанкны валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор 2019 он хүртэлхи хугацаанд алтны олборлолтод ногдох нөөц ашигласны төлбөрийг 2.5 хувь болгож, өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөрийг хүчингүй болгосон УИХ-ын шийдвэр, Монголбанкнаас хөнгөлөлттэй зээлийг алт олборлогчдод олгох төлөвлөгөөг хэрэгжүүлснээр алт олборлолтын хэмжээ 2014-2019 онд эрчимтэй



өсч, Монгол Улсын гадаад валютын нөөц нэмэгдэнэ гэж тооцоолжээ.

Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын нэг гол төрөл болох Концессийн зүйлийн жагсаалтыг 2013 онд шинэчлэн баталсан бөгөөд эдгээрийг хэрэгжүүлэх хүрээнд 2014 онд авто зам, цахилгаан станц, боловсролын салбарт нилээд олон төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Тавантолгой-Гашуунсухайтын төмөр замын барилгын ажлын үргэлжлүүлэн хийж гүйцэтгэх юм байна.

Гадаад орчны эрсдлүүд байгаа хэдий ч дээр дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2014 онд аж үйлдвэрийн салбар 18 хувиар, үүнээс уул уурхайн салбар 25 хувиар, барилгын салбар 15 хувиар, боловсруулах аж үйлдвэрийн салбар 10 хувиар тус, тус өсөхөөр хүлээгдэж байна хэмээн танилцуулгад дурджээ. Аж үйлдвэрийн салбар, барилга угсралт бүтээн байгуулалтын ажлын үр дүнд үйлчилгээний салбар 10 орчим хувиар өсөх төлөвтэй байгаа бөгөөд ингэснээр Монгол Улсын ДНБ 2014 онд 11.2 хувиар өсөхөөр байна хэмээн үзсэн байна.


Монгол Улсын өр ДНБ-ий 80 хувьд хүрчээ



Манай улс өрийн удирдлагагүй, бодлогогүй, үр ашиггүй, хяналтгүй байгаа нь үндэсний аюулгүй байдалд заналхийлж буйг эдийн засагчид анхааруулсаар

ирсэн. АН-ын зүгээс өрийн тааз(босго)-ыг 70 хувьд хүргэх санал оруулсан ч МАН эсэргүүцэж, Өрийн удирдлагын тухай хуулийн төслийг батлахдаа нухацтай хандах ёстой гэж буй юм. Тэд Монгол улсын иргэн бүр дөрвөн сая төгрөгийн өртэй байхад өрийг нэмвэл 2016 онд зургаан саяд хүрнэ гэж үзжээ. Эдийн засагчдын үзэж буйгаар одоогийн байдлаар манай улсын нийт өр ДНБ-ий 80 орчим хувьд хүрсэн гэжээ.

Он гарснаар гадаадын хөрөнгө оруулалттай 81 компани бүртгэгджээ



Энэ оны эхний улирлын байдлаар манай улсад гадаадын хөрөнгө оруулалттай 81 компани бүртгэгдээд байна. Мөн эхний улиралд 294 сая ам.долларын гадаадын шууд

хөрөнгө оруулалт орж ирсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 65 хувиар буурчээ.

Манай улс энэ оноос Гадаадын хөрөнгө оруулалтын газрыг байгуулж, энэ тухай хуулийг хэрэгжүүлж эхэлсэн. Ингэснээр гадаадын хөрөнгө оруулалтын хандлага харьцангуй наашилж байгаа талаар албаныхан мэдээлж буй.